

“Иргэдтэй ажиллах”, “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг зохион байгууллаа

2016.09.28

Сэвхүүл

Монгол улсын Ерөнхийлөгчийн 2007 оны 97 дугаар зарлиг, ЗГ-ын 2007 оны 190 дүгээр тогтоол, Сумын Засаг Даргын үйл ажиллагааны 2013-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.4 дугаар заалтын дагуу “Нээлттэй-хаалга”-ны өдөрлөгийг төр, засгийн бодлого, шийдвэр, төрөөс үзүүлж буй үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй шуурхай хүргэх, иргэдийн санаа бодлыг сонсож үйл ажиллагаандаа тусгах үүднээс сумын албан байгууллагууд болон Говьсүмбэр аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Оюуны өмч, улсын бүртгэлийн хэлтсийн мэргэжилтнүүдтэй хамтран 2016 оны 09-р сарын 28-ны өдрийн 10.00-17.00 цагт сумын төв талбайд зохион байгууллаа.

Тус өдөрлөгийн үеэр 4 байгууллагын 10 мэргэжилтэн ажил үүргийн дагуу холбогдох төрийн үйлчилгээг үзүүлж, мэдээ мэдээлэл хийв. Тус өдөрлөгт давхардсан тоогоор 262 иргэн үйлчлүүлснээс, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын асуудлаар 52 иргэн, Оюуны өмч, улсын бүртгэлийн асуудлаар 28 иргэн, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний асуудлаар 25 иргэн, “Илчлэг-Шивээ” ОНӨҮГ-ын асуудлаар 54 иргэн үйлчлүүлж, 24 өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэн, 158 ширхэг гарын авлага, тараах материал өгч, 103 иргэнийг зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллалаа.

